

## **ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР**

Үндэсний хөгжлийн газар нь Монгол Улсын Их хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах” тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан. Хэдийгээр Үндэсний хөгжлийн газар нь шинээр байгуулагдсан боловч түүхэн замналын хувьд БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 106 дугаар тогтоолоор 1945 онд үүсгэн байгуулагдсан Улсын төлөвлөгөөний комиссоос эхэлж, 1993 онд байгуулагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын газар, мөн 2009 онд байгуулагдсан Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороогоор үргэлжилсэн байна.

### **ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын нэгдсэн болон концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн, бодлогыг зөв зохистой төлөвлөж, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, салбарын хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хот байгуулалтын бодлоготой зөв уялдуулан экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан хүн амын ажиллаж, амьдрах эдийн засгийн таатай орчныг бий болгож, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх явдал мөн.

### **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО:**

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бүсчилсэн хөгжлийн бодлогын болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хувилбар боловсруулах, батлуулах, хөгжлийн томоохон төслүүдийн саналыг нэгтгэн судалгааг зохион байгуулах, зохицуулах, бодлого, хөтөлбөр, төсөлд дүн шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах

Салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар санал боловсруулах, салбарын хөгжлийн бодлогыг хүн амын нутагшил суурьшил, хот байгуулалт, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах замаар салбар хоорондын уялдааг хангах, судалгаа, шинжилгээ хийх, хөгжлийн бодлогын баримт бичгийн мэдээллийн санг эрхлэх

Хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын болон концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын хувилбар санал боловсруулах, хөрөнгө оруулалтын төслийг татварын болон татварын бус хэлбэрээр дэмжих санал боловсруулах

Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл болон хөрөнгө оруулах нөхцөл, боломжийг дотоод, гадаадад сурталчлах, мэдээлэх цогц үйл ажиллагааг тасралтгүй эрхлэн явуулах, улсын хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг нэгтгэн гаргах, хөрөнгө оруулалтын мэдээллийн санг эрхлэн хөтлөх, хөрөнгө оруулагч нарт зөвлөгөө өгөх, мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх

Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, улсын хөгжил, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх